



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2017 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

АЛТАЙ ХОТ
2017 ОН

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ТАХ	Төсөл арга хэмжээ
ББНШК	Баримт бичиг нягтлан шалгах комисс

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь 2017 оныг “АДБОУС-ын хэрэгжилтийг хангах, ажилтнуудын ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарлаж, батлагдсан төсвөөс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ /үйлчлэгч, харуулын цалин/, тэтгэмж урамшууллын зардлыг хасч 229.8 сая төгрөгийн санхүүжилтийг үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 бүлэг 45 нэрийн ажилд хуваарилан, аудитын өртөг 17.5 сая төгрөг нийт 247.3 сая төгрөгийн төсөвтэйгээр хийж гүйцэтгэхээр төлөвлөж, 17 орон тоотойгоор тавьсан зорилтоо хэрэгжүүлэн ажиллалаа.

Эхний хагас жилд төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллалаа. Говь-Алтай аймаг дахь Төрийн Аудитын газар нь санхүүгийн тайлангийн аудит 158, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн 2, нийцлийн 1 аудитыг 8 аудитор, шинжээч нар 1214 хүн өдөр, 3850.8 илүү цагаар ажиллан хийж гүйцэтгэсэн байна.

Эхний хагас жилд хийсэн аудитаар 33,320.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж аудитын явцад 5,682.0 сая төгрөгийг залруулж, 21,937.5 сая төгрөгийн зөрчилд 150 албан тушаалтанд албан шаардлага, 4,463.2 сая төгрөгийн зөрчилд 85 заалт бүхий зөвлөмж өгч, 1,237.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Ажлын хариуцлага алдсан 49 ажилтанд хариуцлага тооцох саналыг томилдог албан тушаалтанд хүргүүлснээс 41 албан тушаалтанд хариуцлага тооцсон байна.

Аудитаар 2017 онд шинээр 2,738.8 сая төгрөгийн үнэлгээ бүхий 145 санхүүгийн үр өгөөж, 212 санхүүгийн бус үр өгөөж бий болгохоор бүртгэж, өмнөх оноос шилжиж ирсэн шийдвэрийн хэрэгжилтийн хамт 2,021.3 сая төгрөгийн үнэлгээ бүхий 95 санхүүгийн үр өгөөж, 74 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч байгууллгуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР:

2.1 Санхүүгийн тайлангийн аудитын баталгаажуулах аудитаар:

Санхүүгийн тайлангийн аудит нь аудит хийлгэсэн байгууллагын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимууд, Нягтлан Бодох Бүргэлийн Олон Улсын стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулах зорилготой.

Аудит хийхдээ Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, 4100-4200, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлаж гүйцэтгэлээ.

Төрийн аудитын газрын хэмжээнд 162 санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитыг хийж дүгнэлт гаргахаас төсвийн ерөнхийлөн захирагчийн 1 санхүүгийн тайлан, шууд захирагчийн 110 санхүүгийн тайлан, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 20 санхүүгийн тайлан, 21 төсөл сан хөтөлбөр, 6 төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн нийт 158 санхүүгийн тайланд дүгнэлт гаргалаа.


“Эрүүл-Ус” ОНӨААТҮГ, “Зураг зүйн товчоо” ОНӨААТҮГ, “Орон сууц” ОНӨААТҮГ Төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайлан, холбогдох баримт материалаа ирүүлээгүй, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн алба нэгдсэн, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих инкубатор төв үйл ажиллагаа явуулаагүйгээс дүгнэлт гаргаагүй бөгөөд “Цөм сүрэг” төрийн өмчит аж ахуйн нэгжийн тайланд аудит хийсэн болно.

Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар 93 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 54 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 11 санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгч 22,166.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж,

5,682.0 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулан, 1,211.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10,306.5 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 2,418.6 сая төгрөгийн зөрчилд 47 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, 2,547.6 сая төгрөгийг зөрчилд зөвлөмж хүргүүлж, 1,984.6 сая төгрөгийн санхүүгийн, 138 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэсэн байна.

Аудитаар өмнөх оны шийдвэрийн хэрэгжилтийн хамт 794.3 сая төгрөгийн үнэлгээ бүхий 97 санхүүгийн үр өгөөж, 53 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч байгууллгуудаар хүлээн зөвшөөрүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийг сүүлийн 3 оноор зэрэгцүүлэн харуулбал:



Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил албан шаардлага, төлбөрийн актыг харьцуулж үзвэл: 2015 онд илэрсэн зөрчил, тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага хамгийн өндөр байсан бол 2016 онд илэрсэн зөрчил 6,753.9 сая төгрөгөөр, тогтоосон төлбөрийн акт 64.5 сая төгрөгөөр, албан шаардлага 3,364.3 сая төгрөгөөр, хариуцлага тооцох албан шаардлага 28.0 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин зөвлөмж 9.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН НИЙТЛЭГ АЛДАА ЗӨРЧИЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилийг хураангуйлан харуулбал:

1. Хөрөнгө, бараа материалыг авсан хэмжээгээр нь тухай бүр орлого авдаггүй, нягтлан бодох бүртгэлд шууд зарлагаар бичилт хийдэг, зөрүүтэй үнээр орлого авдаг, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө зарж борлуулсан байна.
2. Цалингийн урьдчилгааг их хэмжээгээр олгож тухайн жилд суутган тооцоог хийгээгүй байна.
3. Үр дүнгийн урамшууллыг илүү, дутуу тооцдог, мөн урамшуулал, шагналт цалин, ур чадварын нэмэгдэл гэх мэтээр нэг ажлын үзүүлэлтээр давхардуулан хавтгайруулан олгосон байна.
4. Анхан шатны нотлох баримтгүйгээр төсвийн хөрөнгийг захиран зарцуулжээ.
5. Батлагдсан төсвийг бүлгийн дүнгээр, зардлын зүйлээр хэтрүүлэн зарцуулсан.

6. Харилцагчид төлөх төлбөрийг илүү, дутуу төлж санхүүгийн тайланд авлага, өглөгийг тусгадаггүй, тооцоо нийлж акт үйлдээгүй.
7. Тухайн жилийн орлогын тооцоог бодоогүй, НББ-д зөрүүтэй тусгасан.
8. Хүнсний материалын тендерт шалгараагүй иргэн, ААНБ-аас худалдан авалт хийсэн.
9. УИХ-ын 2016 оны 47-р тогтоолыг зөрчиж албан тушаалтны гар утасны зардал, тэмдэглэлт баяр ёслолд төсвөөс зарцуулсан.
10. Төрийн сангийн хяналт хангалтгүй, тэмдэг дарж баталгаажуулаагүй гүйлгээг төрийн сангийн программд шивж оруулсан байна.
11. Жолоочийн шатахууны тооцоог бодоогүй, шатахууны зардлыг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, замын хуудасгүйгээр зарцуулдаг.
12. Удирдлагын буруутай шийдвэрээр ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохирол учруулсан
13. Хоол, үдийн цайны нормативт зардлыг хэтрүүлэн зарцуулдаг, хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлж чанар муудахаар нь ацталсан.
14. Хяналтын байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлдэггүй гарсан зөрчил дутагдлыг дахин давтан гаргадаг.
15. СХС-гийн зээлийн гэрээний дагуу зээлийн төлбөрийг төлүүлдэггүй, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж эрх үүргээ биелүүлдэггүй.
16. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээгээр нийлүүлсэн тракторын үнийг буцаан төлөлтийг тооцоход гэрээт хугацаанд төлүүлээгүй, гэрээний дагуу алдангийг тооцоогүй байна.
17. Батлагдсан орон тооноос илүү хүн ажиллуулсан байна.

Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт: Санхүүгийн тайлангийн 2014-2015 оны аудитаар 762.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 1,967.8 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлалыг хэрэгжүүлээгүй байснаас 17.8 сая төгрөгийн актыг хэрэгжүүлсэн байна. Өмнөх аудитын шийдвэрийн 0.6%-ийг хэрэгжүүлжээ. Эндээс харахад шийдвэрийн хэрэгжилт тун хангалтгүй байна. Биелэгдээгүй актын 60 хувийг СХС-гийн акт эзэлж байна.

СХС-гийн санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 19.9 сая төгрөгийн төлбөрийн актыг харилцагч байгууллагаас Говь-Алтай аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гарган хариуцагчаар төлүүлэхээр маргаан үүсгэн шийдвэрлүүлж байгаа тул мэдээнээс хасагдсан болно.

2.2 Аймгийн Нэгдсэн төсвийн гүйцэтгэл аудитаар:

Аудитаар аймгийн орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа бусад баримт материалд тулгуурлан аудит хийлээ.

Аймгийн аудитын газар нь Говь-Алтай аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийхээс өмнө Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу бүх шатны төсвийн захирагч болон орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд аудит хийж дүгнэлт гаргасан.

Аудитаар 2,667.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж 751.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 1 албан тушаалтанд 1 заалт бүхий албан шаардлага, 1,915.6 сая төгрөгийн зөрчилд 6 заалт зөвлөмж хүргүүлж, 17.4 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бүртгэсэн байна. Аудитаар өгсөн шийдвэрийг тооцох хугацаа болоогүй хэрэгжилтийн шатандаа явж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР:

Гүйцэтгэлийн аудит нь АДБОУС-3000-3100, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлан аудит хийлгэсэн байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн нөөцийг хэрхэн арвич хямгач, үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй ашиглаж байгаад дүгнэлт, гаргаж, зөвлөмж өгөх зорилготой.

Эхний хагас жилд УИХ-ын төсвийн байнгын хорооны захиалга, Үндэсний Аудитын газрын төлөвлөгөө, хөтөлбөрөөр “Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”, “Засгийн газрын векселийн үр дүн” -д гүйцэтгэлийн аудитыг 4 аудитор, шинжээч 24 хүн өдөр гүйцэтгэхдээ 200 илүү цаг ажилласан байна.

“Засгийн газрын өрийн удирдлагын хэрэгжилт, үр дүн”-гийн аудитаар хийх судалгааг хийж УАГ-т хүргүүлсэн.

УИХ-ын төсвийн байнгын хорооны захиалга, Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр “Концессын тухай хуулиар төрийн өмчийн концессийн зүйлийн жагсаалтанд батлагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”, “Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүн”-д хийх 3 аудит улирал дамжиж хийгдэж байна.

Гүйцэтгэлийн аудитаар 3,318.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 3,3318.5 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж, 263.0 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 2 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэлээ. Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Өмнөх оноос шилжин ирсэн 1 зөвлөмж, 5.8 сая төгрөгийн актыг барагдуулж, 5.8 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, тайлант оны 2 санхүүгийн бус үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

3.1 Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын талаар:


Гүйцэтгэлийн аудитаар УТХО, ОНТХО-аар хийсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг үзэж дүгнэлт гаргаж, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын хувийн хэргийг баяжуулан ажиллалаа.

Улсын төсвөөс хэрэгжиж байгаа 34 хөрөнгө оруулалтын ажлууд нь аймаг орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа хэдий ч түүний ажлын явц хэтэрхий удаашралтай байна. Эрх шилжиж ирсэн 22 хөрөнгө оруулалтын ажлаас 5 ажлын гүйцэтгэл хангалтгүй 70-75%-тай хэрэгжиж байна. Эрх шилжих ирээгүй ажлуудын дундаж гүйцэтгэл 53%-тай байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 25 ажил хийгдсэнээс Алтай сумын цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэх ажил дуусаагүй, бусад хөрөнгө оруулалтын ажлууд бүрэн дууссан байна. Дээрхи ажлуудын 30 хувь нь аймгийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын “Бидний–Алтай” мөрийн хөтөлбөрт, 70 хувь нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйл буюу Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд багтсан ажлууд байна.

Аудитаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний ажлын явц удааширалтай, гэрээний хэрэгжилт, түүнд тавих хяналт хангалтгүй байна” гэсэн дүгнэлт өгч 3,287.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж 3,287.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 3 албан тушаалтанд 7 заалт бүхий албан шаардлагыг хүргүүлж, 2 хүнд хариуцлага тооцох албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлж 128.7 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 2 санхүүгийн бус үр өгөөж бий болгохоор бүртгэж, 2 санхүүгийн бус үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

УТХО болон орон нутгийн хөрөнгө оруулалтын аудитаар илэрсэн төлбөр зөрчлийг сүүлийн 3 оноор зэрэгцүүлэн харуулбал:



Сүүлийн 3 жилийн аудитаар илэрсэн зөрчлийг хуулийн заалтаар нэгтгэж үзэхэд барилга байгууламжийн ажлын зураг төсвийн магадлалийн ерөнхий дүгнэлт гаргаагүй, захиалагчийн хяналтын зардлыг хяналт хэрэгжүүлсэн байгууллагад шилжүүлдэггүй, захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлдэг, хөрөнгө оруулалтыг данс бүртгэлд бүрэн тусгадаггүй, эксперт хийлгээгүй зураг, төсөвгүй ажлыг ИТХ-аар баталдаг, шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлыг дутуу, чанаргүй хийсэн байхад хүлээн авдаг зөрчлүүд давтан гарсан байна.

Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт:

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүлжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн аудитаар 11.8 сая төгрөгийг акт тогтоож, 745.0 сая төгрөгийн зөрчилд 6 зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлснээс 745.0 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж 11.8 сая төгрөгийн актыг хэрэгжүүлээгүй байна.

3.2 Засгийн газраас олгосон векселийн үр дүнд хийсэн аудитын талаар:

Говь-Алтай аймагт он дамжин хэрэгжиж байгаа 12 ТАХ-ээс 3 ТАХ нь эрх шилжиж орон нутагт ирсэн бөгөөд векселээр санхүүжүүлсэн байна. Тайшир сумын соёлын төвийн барилгын ажилд 189.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож ашиглалтанд хүлээн авсан байна. Алтай сумын сургуулийн өргөтгөлийн барилгын ажил 130.0 сая төгрөгийг олгож гүйцэтгэл 70% байна. Цогт сумын Баянтоорой тосгоны байр, гал тогооны барилгын ажил 281.0 сая төгрөгийг олгож ашиглалтанд бүрэн хүлээн авчээ.

Эдгээр эрх нь шилжсэн 3 хөрөнгө оруулалтын ажлыг газар дээр нь очиж үзэхэд барилгын дотор ханын замаск шавардлага нэлэнхүйдээ ховхорч хагаралт үүссэн, гүйцэтгэгч тал гэрээг сунгах хүсэлт гаргасан боловч, одоо болтол сунгаагүй, зарим өрөөний таазнаас дусаал гоожсоны улмаас паркетан шал овойж хөндийрсөн, зарим өрөөний паар хэсэг газраа задарсан, хананд зарим газраа хагаралт үүссэн. Мөн бохирын шугамд хөлдөлт үүссэний улмаас ашиглах боломжгүй зөрчлүүд илэрсэн.

Эрх нь шилжээгүй 12 ТАХ-г үзэхэд гэрээний дагуу санхүүжилтээ авсан боловч гүйцэтгэл хангалтгүй байлаа.

Аудитаар 31.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 2 албан тушаалтанд 4 заалт албан шаардлага хүргүүлж, 31.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бүртгэлээ. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн хугацаа болоогүй байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЛААР:

Нийцлийн аудит нь АДБОУС-4000-4200, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлаж тодорхой шалгах зүйл шалгуур болон тодорхойлсон холбогдох эрх зүйн акт шалгагдагч байгууллагын дүрэм журам хууль тогтоомж хуулийн дагуу хэрэгжиж буй эсэхэд бие даасан дүгнэлт өгдөг.

Эхний хагас жилд УИХ-ын төсвийн байнгын хорооны захиалга, Үндэсний Аудитын газрын төлөвлөгөө, хөтөлбөрөөр “ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”-д нийцлийн аудитыг 3 аудитор, шинжээч 110 хүн өдөр гүйцэтгэхдээ 462.4 илүү цаг ажилласан.

Нийцлийн аудитаар 5,168.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 26.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,168.4 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж, 473.8 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бүртгэлээ.

Өмнөх оноос шилжин ирсэн 1 зөвлөмж, 11.4 сая төгрөгийн акт, 24.0 сая төгрөгийн албан шаардлага, тайлант оны 3,417.0 сая төгрөгийн албан шаардлагыг барагдуулж, 109.1 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 19 санхүүгийн бус үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

4.1 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын байдлын аудитын талаар:

Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдал хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулан дүнг УИХ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 13 тоот тогтоолоор ОНХС-ийн орлогыг 6,569.7 сая төгрөгөөр төлөвлөж, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс сумдын ОНХС-д 3,941.4 сая төгрөг, аймгийн ОНХС-д 2,627.9 сая төгрөг нийт 6,569.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталсан байна.


Бодит гүйцэтгэлээр ОНХС-аас 5,693.6 сая төгрөгийн санхүүжилт олгогдон, сумдын ОНХС-д 3,102.5 сая төгрөг, аймгийн ОНХС-д 2,591.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хуваарилж олгожээ.

Тус аудитаар өмнөх онуудад хэрэгжсэн болон 18 сум, аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг газар дээр нь очиж үзсэн.

Аудитаар **“ОНХС-гийн эх үүсвэрээс 769.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 25 дахин өссөн үзүүлэлттэй, мөн дотоодын хяналт хангалтгүй байна”** гэсэн дүгнэлт өгч 5,168.7 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн 26.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5,142.4 сая төгрөгийн зөрчилд 72 заалт бүхий зөрчил арилгуулах албан шаардлагыг холбогдох байгууллага болон албан тушаалтанд хүргүүлжээ.

Аудитаар 473.8 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 72 санхүүгийн үр өгөөж бүртгэж, 73.7 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг, 19 санхүүгийн бус үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

**ОНХС-гийн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийг сүүлийн 3 оноор зэрэгцүүлэн
харуулбал:**



ОНХС-ийн аудитын сүүлийн 3 жилийн аудитаар илэрсэн зөрчлийг хуулийн заалтаар нэгтгэж үзэхэд Иргэдээс санал аваагүй, эрэмблэгдээгүй төсөл арга хэмжээг ЗДТГ-аас оруулан батлуулдаг, ИТХ нь шууд баталдаг, ОНХС-гийн зааварт нийцээгүй төсөл арга хэмжээ, төрийн бус байгууллагыг санхүүжүүлдэг, урсгалд зардалд зарцуулдаг, захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлдэг, хөрөнгө оруулалтыг данс бүртгэлд бүрэн тусгадаггүй, шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлыг дутуу, чанаргүй хийсэн байхад хүлээн авдаг зөрчлүүд давтан гарсан байна.

Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт:

ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн аудитаар 54.1 сая төгрөгийг акт тогтоож, 18 албан тушаалтанд 3,487.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 16 албан тушаалтанд хариуцлага тооцоулах албан шаардлага хүргүүлснээс 14.1 сая төгрөгийн актыг барагдуулж, 3,181.8 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан байна. Тогтоосон актын 26 хувийг, зөрчил арилгуулах албан шаардлагын 91.2 хувийг, хариуцлага тооцох албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлжээ.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн дараахь арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна. Үүнд:

1. Мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн сургалт, шалгалтыг чанартай зохион байгуулж санхүүчдийн мэдлэг, ёс суртахуун, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх
2. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, актыг барагдуулах ажлыг зохион байгуулж төсвийг хохиролгүй болгох арга хэмжээ авч үр дүнг тооцох
3. Төрийн аудитын байгууллагын өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх нь тухайн байгууллагын санхүүгийн зөрчил дутагдал гаргахгүй байх үндэслэл болно гэдгийг ухамсарлаж ажиллах
4. Эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд чанартай хийж тооцоог бодож санхүүгийн тайланд тусгах
5. Төсвийн төлөвлөлтийг хэрэгцээ шаардлагыг тооцсоны үндсэн дээр оновчтой бодитой тооцон, хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах

6. СХС-гийн зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлж түүнд тавих хяналтыг сайжруулж, хариуцлагыг өндөржүүлэх ажил зохион байгуулах нь нэн чухал асуудал болж байна.
7. Байгууллагуудын хүнсний материалын худалдан авалт, гэрээний үнэлгээнд хяналт тавьж ажиллах
8. Хуулийн дагуу хязгаарлалттай, сөрөг дүгнэлт авсан байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт хариуцлага тооцох
9. Санхүүгийн тайландаа хуулийн хугацаанд аудит хийлгээгүй байгууллагын удирдлагад хуулийн дагуу хариуцлага тооцох
10. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих инкубатор төвийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг судалж шийдвэрлэх
11. Барилга байгууламжийн ажлын зураг төсвийн магадлангийн дүгнэлтийг гаргаж хэвших
12. Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлыг гэрээний дагуу хугацаанд нь олгож явцын хяналтыг эрчимжүүлэх
13. Эксперт хийгдээгүй, зураг төсөвгүй хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-аар баталдаг явдлыг таслан зогсоож, худалдан авах ажиллагаа зарлахгүй байх
14. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ажил гүйцэтгүүлэх гэрээнд заалт болгон оруулж санхүүжилттэй уялдуулах
15. Гэрээнд заагдсан баталгаат хугацааны дагуу чанаргүй хийгдсэн ажлуудыг гүйцэтгэгчээр дахин засварлуулах
16. Хөрөнгө оруулалтын ажлыг бүрэн дууссаны дараа хүлээн авах ажлыг зохион байгуулж улсын комисс хүлээн авсан хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж хэвших
17. ОНХС-гийн хөрөнгөөр иргэдээс санал авсан, эрэмбэлэгдсэн, ОНХС-гийн зааварт нийцсэн төсөл арга хэмжээг санхүүжүүлэх
18. ОНХС-гийн хөрөнгөөр урсгал зардал болон төрийн бус байгууллагыг санхүүжүүлэхгүй байх
19. ОНХС, ОНХО-ын хөрөнгөөр орон нутгийн тулгамдсан хөрөнгө оруулалтыг түлхүү хийх шаардлагатай байна.

ТАВДУГААР БҮЛЭГ. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХҮСЭЛТ БОЛОН ӨӨРИЙН САНААЧЛАГААР ХИЙСЭН АУДИТ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

Эхний хагас жилд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын захиалгаар хийгдэх аудит нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 дугаар улиралд хийхээр батлагдсан болно.

Аймгийн ИТХ-ын захиалгаар хийгдсэн “Газрын тухай хууль, түүнтэй холбоотой бусад хууль эрх зүйн актын хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын шийдвэрээс 13.1 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт, 1,445.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага хэрэгжээгүй байснаас тайлант онд 1,445.9 сая төгрөгийн албан шаардлага хэрэгжиж 1,112,1 сая төгрөгийн үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

Төсвийн тухай хууль, Төрийн аудитын хууль, Санхүүгийн тайлангийн аудитын журмын хүрээнд 2017 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын танилцуулга, санал зөвлөмжийг аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүллээ.

Эхний хагас жилд хийсэн аудитын тайлан, шийдвэр, хагас жилийн үйл ажиллагааны тайланг аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлсэн.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ДОТООД АЖЛЫН ТАЛААР:

Тэргүүлэх аудитор орон нутаг хариуцсан Ерөнхий аудиторын орлогчтой гэрээ байгуулан хэрэгжүүлж ажиллалаа.

Аудитын менежер, аудитор, шинжээч нар болон үйлчилгээний ажилтнууд Тэргүүлэх аудитортой үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Аудитын шийдвэрийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй 15 байгууллагын удирдах албан тушаалтанд 407.2 сая төгрөгийн акт, 2,658.4 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллах мэдэгдлийг хүргүүлээд байна.

ҮАГ-аас зохион байгуулагдсан онлайн сургалтанд тогтмол оролцон аудитын явцын талаар мэдээлэл хийж санал солилцож “Web site”-д цаг үеийн мэдээлэл болон аудитын тайлангуудыг тавьсан байна.

Эхний хагас жилд аудит хийлгэх тухай 1, бусад асуудлаар 10 өргөдөл, гомдол хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэж 1 өргөдлийг шийдвэрлэх судалгааны шатанд явж байна.

ҮАГ-аас ирүүлсэн хугацаатай мэдээ судалгаа, аудитын журамд өгөх саналыг хугацаанд нь хүргүүлсэн.

Энэ онд хийх явцын буюу завсрын аудит, 2018 онд санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллага, төсөл сангийн судалгааг гаргаж ҮАГ-т хүргүүлсэн.

Аудитор, шинжээч нараас оны эхэнд “Сургалтын хэрэгцээ тодорхойлох” саналын хуудсаар санал авч 2017 онд 45 сэдвээр сургалт зохион байгуулж, улирал бүр тестын шалгалт авахаар төлөвлөгөө гарган Тэргүүлэх аудиторoor батлуулж сургалтыг бүрэн зохион байгууллаа.

Тэргүүлэх аудитор, аудитын менежер, аудитор нар Хууль зүй дотоод хэргийн яам, аймгийн ЗДТГ-аас хамтран зохион байгуулж буй “Зөрчлийн тухай”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай”, “Эрүүгийн”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуулийн сургалтанд хамрагдлаа.

Эхний хагас жилд хийсэн СТА, НА, ГА тус бүрд бүрд 1, 2 дугаар шатны чанарын хяналтыг хийж баримтжуулж ажилласан.


Байгууллагын 7 хоногийн ажлын тайланг “Цахим оффис”-д тухай бүр нь байршуулан ажиллалаа.

Бусад ажлын талаар:

ҮАГ-ын Тамгын газрын хүний нөөцийн албаны менежерийн өгсөн зааврын дагуу 17 ажиллагсадын хувийн хэргийн хавтасыг шинэчлэн бүрдэлд дахин хяналт тавьж баталгаажуулалт хийлээ.

Байгууллагын ББНШК-оос албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт хийж бичиг хэргийн ажилтанд 4 заалт бүхий Зөвлөмж өгч хэрэгжилтийг хангууллаа.

Байгууллагын гадна, дотор тохижилт, ногоон байгууламжийг ажилчдын санаачилгаар арчилж аймгийн шилдэг тохижилттой байгууллагаар шалгарлаа.



ДОЛДУГААР БҮЛЭГ: САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР:

Байгууллагын 2017 оны эхний хагас жилд 133.1 сая төгрөгийн орлого, санхүүжилттэй үйл ажиллагаа явуулан төсвийг зохих хууль журам, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж нягтлан бодох бүтгэлийг хөтлөн санхүүгийн тайлан мэдээг зохих цаг хугацаанд нь гаргаж хэрэглэгч болон удирдлагыг санхүүгийн мэдээллээр бүрэн хангаж ажиллалаа. Мөн санхүүгийн тайланг улирал тутам хамт олны хуралд танилцуулсан.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах, Төсвийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах үүднээс өөрийн санхүүгийн үйл ажиллагааны зарцуулалтыг www.audit.mn цахим сайтад тогтмол мэдээлсэн.

Батлагдсан санхүүжилтийн хэмжээнд эхний хагас жилд хийсэн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар аймгийн 18 сумд ажилласан ажилтнуудын албан томилолт, шатахууныг цаг хугацаанд нь бүрэн гаргаж өгч аудитыг хурдан шуурхай хийж гүйцэтгүүлээ.

Эхний хагас жилд байр ашиглалттай холбоотой зардлыг 5.3 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардал зардлыг 0.4 сая төгрөгөөр, албан томилолтын зардал 0.4 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж хүрэлцэхгүй байгаа цалин хөлсний зардалд гүйлгэн зарцуулахаар хүсэлт гаргалаа.

Санхүүгийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдлийг холбогдох тооцоо, судалгааны хамт хуулийн хугацаанд ҮАГ-т хүргүүлсэн.

НАЙМДУГААР БҮЛЭГ: ДҮГНЭЛТ, САНАЛ:

Санхүүгийн тайлангийн аудит 158, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн 2, нийцлийн 1 аудитыг хугацаанд хийж хүргүүлж, 3 аудит төлөвлөлт, гүйцэтгэлийн шатандаа хийгдэн үйл ажиллагааны төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Эхний хагас жилд хийсэн аудитаар өгсөн шийдвэрээс 253.2 сая төгрөгийн акт, 12,478.2 сая төгрөгийн албан шаардлага, өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрээс 48.1 сая төгрөгийн акт, 5,431.3 сая төгрөгийн албан шаардлагыг биелэлтийг хангуулсан байна.

Эхний хагас жилд 2,738.8 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 212 санхүүгийн бус үр өгөөж бүртгэж, өмнөх оноос шилжин ирсэн үр өгөөжийн хамт 2,021.3 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 74 санхүүгийн бус үрөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж 1 төгрөгт ногдох үр өгөөжийг 15.93 төгрөгт хүргэн ажиллалаа.

Говь-Алтай аймаг дахь Аудитын газрын цалингийн зардал хүрэлцээгүй хагас жилийн санхүүгийн тайлангаар 0.7 сая төгрөгийн НДШ-ийн өртэй гарсан. Ажиллагсдын цалингийн зардлыг бодитоор тооцон батлагдсан төсөвтэй харьцуулан үзэхэд 5.0 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.

Мөн өөрийн байр болон авто машинтай холбоотойгоор гарч байгаа урсгал засварын зардал огт төсөвлөгдөөгүй учраас эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар 0.4 сая төгрөгийн сэлбэгийн өглөгтэй байгаа тул төсвийн хэмнэлтийг гүйлгэн зарцуулах эрх олгох хүсэлтийг шийдвэрлэж өгнө үү.

Та бүхний ажилд амжилт хүсье.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР